



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2022/01/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас: www.audit.mn Дорноговь аймаг 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий	
	Утас: 70522734	Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn
	Аудитын менежер:	У.Оюунтүлхүүр
	Утас: 70523020	Цахим хаяг: oyuntulkuur.u@audit.gov.mn
	Аудитор:	Д.Дэмбэрэлсүрэн
		Цахим хаяг: demberelsurend@audit.gov.mn
	Аудитор:	Т.Мөнхтогтох
		Цахим хаяг: munkhtogtokht@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	9
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	12
3.5.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	12
3.5.2 Авлага	13
3.5.3 Урьдчилгаа	14
3.5.4 Бараа материал	15
3.5.5 Үндсэн хөрөнгө	15
3.5.6 Урт хугацаат хөрөнгө оруулалт	16
3.5.7 Өр төлбөр	16
3.5.8 Засгийн газрын хувь оролцоо	17
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	18
3.7 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
3.7.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
3.8 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	20
3.9 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
4. Аудитын илрүүлэлт	20
4.1 Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн албан шаардлага	21
4.2 Төсвийн ерөнхийлөн захирагчид өгсөн зөвлөмж	22
5. Аудитаар илэрсэн асуудлын бүртгэл	24

Товчилсон үгийн жагсаалт

ААН	Аж ахуйн нэгж
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОТНДШ	Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл
ДГА	Дорноговь аймаг
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НААУ	Нийтийн аж ахуйн үйлчилгээ
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНӨААН	Орон нутгийн өмчит аж ахуй нэгж
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ОНӨХХК	Орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
СОК	Сумын онцгой комисс
СХС	Сум хөгжүүлэх сан
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМТ	Эрүүл мэндийн төв

1. Төрийн аудитын санал, дүгнэлт



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гуламж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2022.04.20 № 16/394

танай _____ -ны № _____ -т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА О.БАТЖАРГАЛ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Дорноговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР _____ Т.ГАН-ӨЛЗИЙ



010020168

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/			
Код:	Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	27,887,301.2	31,249,715.9
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	8,926,787.3	9,086,193.4
33	АВЛАГА	7,293,569.6	9,372,573.2
34	УРЬДЧИЛГАА	1,834,952.8	1,170,514.1
35	БАРАА МАТЕРИАЛ	9,244,662.0	11,560,126.1
36	НӨӨЦИЙН БАРАА	20,267.7	60,309.1
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	567,061.8	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	196,524,550.0	213,182,701.5
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	40,614.2	4,452,341.0
37300	Урт хугацаат зээл	40,614.2	4,452,341.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	196,483,935.8	208,730,360.5
39200	Биет хөрөнгө	186,667,910.3	197,273,854.5
39300	Биет бус хөрөнгө	9,816,025.6	11,456,506.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	224,411,851.2	244,432,417.5
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	20,490,704.8	23,112,420.2
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,808,019.0	5,230,158.2
41300	Өглөг	3,129,272.5	5,211,416.8
41400	Урьдчилж орсон орлого	678,746.6	18,741.4
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	16,682,685.8	17,882,262.0
42200	Урт хугацаат зээл	16,682,685.8	17,882,262.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	203,921,146.4	221,319,997.3
51	Засгийн газрын хувь оролцоо	203,921,146.4	221,319,997.3
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	53,850,341.2	56,106,097.0
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	23,889,382.6	23,029,055.3
51102	Өмч /хувийн/ /ТӨҮГ/	20.0	1,020.0
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	676,174.7	514,379.7
51200	Хуримтлагдсан үр дүн	77,736,528.5	99,147,124.2
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	47,768,699.5	42,522,321.1
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	224,411,851.2	244,432,417.5

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	144,486,735.9	135,296,828.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО	28,660,903.6	32,666,318.1
110	Орлогын албан татвар	18,526,118.0	20,040,959.2
1100	Хувь хүний орлогын албан татвар	19,726,118.0	20,844,777.4
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(1,200,000.0)	(803,818.3)
113	Хөрөнгийн албан татвар	1,749,009.6	2,610,919.4
118	Бусад татвар, төлбөр, хураамж	8,385,776.0	10,014,439.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	93,304,449.2	85,671,520.7
120	Нийтлэг татварын бус орлого	41,956,348.0	31,413,038.1
121	Хөрөнгийн орлого	33,033.0	30,465.0
122	Тусламжийн орлого	17,628.9	410.5
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	51,297,439.4	54,227,607.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	22,521,383.1	16,958,989.4
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	107,626,085.9	113,408,416.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	107,626,085.9	113,408,416.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	104,127,843.7	110,578,135.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	34,890,507.8	38,355,734.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,415,925.5	5,012,579.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,594,437.0	7,548,444.8
2104	Хангамж, бараа материалын зардал	32,728,309.3	26,461,978.3
2105	Нормативт зардал	2,797,960.8	7,930,358.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	517,255.5	626,983.6
2107	Томилот, зочны зардал	236,614.4	201,587.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,359,246.9	13,540,924.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,587,586.4	10,899,544.4
212	ТАТААС	358,536.7	327,620.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,139,705.5	2,502,660.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	36,860,650.0	21,888,411.4
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,469,133.9	3,330,156.9
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)- (V)	35,391,516.1	18,558,254.6

2.3 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	126,474,119.5	127,952,160.1
11	ТАТВАРЫН ОРЛОГО	28,652,132.6	32,667,914.1
110	Орлогын албан татвар	18,526,118.0	20,042,555.2
1100	Хувь хүний орлогын албан татвар	19,726,118.0	20,846,373.4
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(1,200,000.0)	(803,818.3)
113	Хөрөнгийн албан татвар	1,749,009.6	2,610,919.4
118	Бусад татвар, төлбөр, хураамж	8,377,005.0	10,014,439.6
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	2,453,567.4	3,525,908.5
1181	Газрын төлбөр	5,383,399.4	5,724,220.8
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	540,038.2	763,929.6
1183	Бусад татвар	-	380.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	75,107,534.2	80,096,644.8
120	Нийтлэг татварын бус орлого	23,759,520.3	25,838,152.7
121	Хөрөнгийн орлого	33,033.0	30,465.0
122	Тусламжийн орлого	17,541.5	420.0
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	51,297,439.4	54,227,607.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	22,714,452.7	15,187,601.1
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	86,017,569.6	92,988,434.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	86,017,569.6	92,988,434.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	82,413,332.1	90,036,293.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	40,264,897.6	41,527,456.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,729,094.7	6,306,584.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,909,510.8	8,946,830.0
2104	Хангамж, бараа материалын зардал	9,059,947.3	10,373,259.1
2105	Нормативт зардал	2,589,693.9	2,471,440.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	755,466.8	910,137.4
2107	Томилолт, зочны зардал	243,197.7	183,842.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,674,296.8	15,466,875.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,187,226.5	3,849,866.2
212	ТАТААС	358,536.7	327,620.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,245,700.9	2,624,520.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	40,456,549.8	34,963,725.8
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	36,824.1	486.0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	37,184,016.7	35,035,640.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	37,184,016.7	35,035,640.8
2200	Дотоод эх үүсвэрээр	37,184,016.7	35,035,640.8
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(37,147,192.6)	(35,035,154.8)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	206,898.3	230,835.1
14	Бусад эх үүсвэр	900,000.0	1,238,617.8
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	693,101.7	1,007,782.8
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	3,516,255.6	159,406.1
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,410,531.8	8,926,787.3
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	8,926,787.3	9,086,193.4

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	169,131,037.7	169,131,037.70
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-1,003,532.8	-1,003,532.80
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	168,127,504.9	168,127,504.90
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	355,616.3	355,616.30
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	31,682.0	31,682.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-
7	Өмчид гарсан өөрчлөлт	14,827.2	14,827.2
8	Зарласан ногдол ашиг	-	-
9	Тайлант үеийн үр дүн	35,391,516.1	35,391,516.1
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	203,921,146.4	203,921,146.4
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	203,921,146.4	203,921,146.4
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	3,911,234.5	3,911,234.5
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	207,832,380.9	207,832,380.9
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-4,652,173.0	-4,652,173.0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	477,984.5	477,984.5
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	56	56
17	Өмчид гарсан өөрчлөлт	-722,853.0	-722,853.0
18	Зарласан ногдол ашиг	-	-
19	Тайлант үеийн үр дүн	18,558,254.6	18,558,254.6
20	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	221,319,997.3	221,319,997.3

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/					
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	101,738,998.8	87,805,029.6	13,933,969.2	86.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	68,851,273.5	62,863,660.6	5,987,612.9	91.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	65,024,738.8	61,155,947.5	3,868,791.3	94.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	36,564,384.8	35,961,878.8	602,506.0	98.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,974,341.1	4,706,795.0	267,546.1	94.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,990,366.3	7,511,882.1	478,484.2	94.0
2104	Хангамж, бараа материалын зардал	1,843,757.6	1,745,498.5	98,259.1	94.7
2105	Нормативт зардал	1,676,639.4	1,478,444.8	198,194.6	88.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,908,680.9	1,859,223.9	49,457.0	97.4
2107	Томилолт, зочны зардал	213,690.3	168,119.3	45,571.0	78.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,692,485.3	5,444,145.6	1,248,339.7	81.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,160,393.1	2,279,959.4	880,433.7	72.1
212	ТАТААС	346,420.7	327,620.7	18,800.0	94.6
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	346,420.7	327,620.7	18,800.0	94.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,480,114.0	1,380,092.4	2,100,021.6	39.7
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	2,211,686.8	212,000.0	1,999,686.8	9.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,268,427.2	1,168,092.4	100,334.8	92.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	32,887,725.3	24,941,369.0	7,946,356.3	75.8
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	101,738,998.8	91,653,733.9	10,085,264.9	90.1
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	54,227,607.0	53,697,906.6	529,700.4	99.0
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	34,891,310.9	34,361,610.4	529,700.5	98.5
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	19,336,296.1	19,336,296.2	(0.1)	100.0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	43,842,756.4	35,237,326.4	8,605,430.0	80.4
320001	Орон нутгийн төсвөөс	43,842,756.4	35,237,326.4	8,605,430.0	80.4
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	294,888.4	248,073.2	46,815.2	84.1
330001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	248.1	(248.1)	
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	294,888.4	247,825.1	47,063.3	84.0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	3,373,747.0	2,470,427.7	903,319.3	73.2

350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,117,984.8	1,943,379.1	(825,394.3)	173.8
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	461,970.0	527,048.6	(65,078.6)	114.1
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	1,793,792.2	-	1,793,792.2	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	2,658,294.1	(2,658,294.1)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	6,506,998.4	(6,506,998.4)	

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Код	Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/ ТӨЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,281,341.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,758,432.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,618,350.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	133,706.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,163.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,360.3
2104	Хангамж, бараа материалын зардал	199,651.1
2105	Нормативт зардал	615,695.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	323,034.8
2107	Томилолт, зочны зардал	15,198.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,371,167.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	903,371.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,140,082.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	329,277.1
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	810,805.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	522,908.8
2200	Дотоод эх үүсвэрээр	522,908.8
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	7,341,180.4
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,341,180.4
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	137,800.0
131103	ЗГНХ,ЗДНХ,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	110,038.1
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,945,418.2
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,504,688.2
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	643,235.9
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	59,839.4
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	59,839.4

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дорноговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд ажил гүйлгээний анги, тодруулга, дансны үлдэгдэлтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Дэмбэрэлсүрэн, Т.Мөнхтогтох нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер У.Оюунтүлхүүр, дарга, тэргүүлэх аудитор Т.Ган-Өлзий нар тус тус хэрэгжүүлсэн.

Дорноговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 02/417 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Дорноговь аймаг “Экологийн тэнцвэрт байдлыг хадгалсан, иргэн бүр нь тогтвортой хөгжлийн боловсролтой, эрүүл, аюулгүй амьдрах орчныг бүрдүүлсэн, олон тулгуурт эдийн засагтай, амьжиргааны түвшин өндөр, үндэсний хэмжээнд өрсөлдөх чадвараар тэргүүлэгч аймаг болно” гэж эрхэм зорилгоо тодорхойлсон байна.

Дорноговь аймгийн хөгжлийн хэтийн зорилтыг хангахад дараах стратегийн зорилтыг дэвшүүлсэн байна. Үүнд,

- Байгалийн нөөц баялгийг зөв зохистой ашиглаж, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэн, орчны бохирдол, доройтлыг бууруулна.
- Хүн амын хөдөлмөр эрхлэлт, ногоон ажлын байрыг нэмэгдүүлэх замаар ажилгүйдэл, ядуурал, нийгмийн эмзэг байдлыг бууруулж, амьжиргааны түвшинг дээшлүүлнэ.
- Иргэн бүрийн тогтвортой хөгжлийн боловсролыг дээшлүүлж, байгальд ээлтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлнэ.
- Байгаль орчинд сөрөг нөлөөгүй экспортын чиг баримжаатай үйлдвэрлэл, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжиж, хариуцлагатай уул уурхай, тогтвортой хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрлэл, аялал жуулчлалыг тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлнэ.
- Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулж, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.
- Хууль ёсыг эрхэмлэсэн, иргэдэд хүртээмжтэй, ил тод, хариуцлагатай, иргэдийн оролцоог бүх шатанд хангасан нэгдмэл бодлоготой сайн засаглалыг бэхжүүлнэ.

Тайлант 2021 оныг “Бизнесийн хөгжлийг дэмжих жил” болгон зарласан байна. Уг зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлж ажилласан байна. Үүнд:

- “Ковид-19” цар тахлын үеийн эрсдэлийг даван туулах арга хэмжээ;
- Орон нутгийн бизнесийн орчныг сайжруулах арга хэмжээ;

- Төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар бизнесийн үйл ажиллагааг дэмжих.

Дорноговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нь:

- Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг хариуцан зохион байгуулж, үр дүнг хариуцах;
- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хариуцан зохион байгуулж, үр дүнг хариуцах, аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлаар төлөвлөгөө, хөтөлбөрийн төсөл боловсруулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулж, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх;
- Аймгийн төсвийн төсөл, түүний тодотголын төслийг боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах, төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах;
- Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн чиг үүргийг хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлэх, аймгийн өмчийн эзэмшил, ашиглалтыг зохион байгуулж, аймгийн өмчийг бусдад эзэмшүүлэх, түрээслэх, худалдах, хувьчлах зэрэг асуудлаар захиран зарцуулах санал боловсруулж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулан шийдвэрлүүлэх, энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасан асуудлаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн төслийг боловсруулж, холбогдох тооцоо, үндэслэл бүхий саналыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулж хэлэлцүүлэх;
- Нутаг дэвсгэрийнхээ татварын албыг удирдлагаар хангах, татварын орлогыг хууль тогтоомж, Хурлын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах;
- Аймгийн хэмжээний томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулагчдыг татан оролцуулах арга хэмжээ авах чиг үүрэгтэй.

Өмнөх оны аудитаар анхаарал татахуйц асуудалд тусгагдсаны дагуу Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэгдсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна” гэж заасны дагуу Санхүүгийн хяналт, аудитын алба нь дотоод хяналтыг хэрэгжүүлж байна.

Дорноговь аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2020 оны 12 дугаар сарын 10-ны өдөр аймгийн Засаг даргаар 2021 онд хэрэгжүүлэх санхүүгийн хяналт, шалгалт болон дотоод аудитын нэгдсэн удирдамжаар 46 санхүүгийн хяналт шалгалт, 6 дотоод аудит хийхээр төлөвлөж батлуулсан байна.

Тайлант хугацаанд нийт төлөвлөгөөт хяналт шалгалтад 50, төлөвлөгөөт бус хяналт шалгалтад 23 аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулж, шалгалтаар 3,949.5 сая төгрөгийн төлбөр зөрчил илрүүлж, орон нутгийн төсвийн орлогын дансанд 3,668.5 сая төгрөгийн, тухайн байгууллагын дансанд болон эргүүлж олгуулахаар 276.2 сая төгрөгийн, 221 улсын /ахлах/ байцаагчийн акт тогтоогдсоноос тайлант хугацаанд 97.2 сая төгрөгийг орон нутгийн

төсвийн орлогын дансанд, 142.3 сая төгрөгийг тухайн байгууллагын дансанд болон эргүүлж олгон, улсын /ахлах/ байцаагчийн 3,518.3 сая төгрөгийн акт, албан шаардлагын хугацаа болоогүй, 6.2 сая төгрөгийн акт Цагдаагийн газар шалгагдаж байна гэж тайлагнасан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дорноговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт хөрөнгө болох 244,432.4 сая төгрөгөөс 1 хувиар буюу 2,444.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг тогтоосон төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 1,955.5 сая төгрөгөөр тогтоосон. Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 8,926.8 сая, эцсийн үлдэгдэл 9,086.2 сая төгрөг болж, 159.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл, сая төгрөг

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	8.0	26.8	18.8
Банканд байгаа бэлэн мөнгө	8,918.8	9,059.4	140.6
Дүн	8,926.8	9,086.2	159.4
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	361.6	509.6	148.0
Төсөл/ сан	2,660.4	6,466.9	3,806.5
Төрийн сан	4,676.5	1,496.3	-3,180.2
ОНӨААН	1,228.3	613.4	-614.9
Дүн	8,926.8	9,086.2	159.4

Эх сурвалж: Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Банканд байршиж буй 9,059.4 сая төгрөгөөс гадаад валютаарх үлдэгдэл “Говь консалтинг менежмент” ХХК 89.2\$ буюу тухайн үеийн Монгол банкны ханш болох 2849 төгрөгөөр тооцож дансны нийт үлдэгдэлдээ тайлагнасан байна.

Нийт мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн 509.6 сая төгрөг төсөвт байгууллагын, 6,466.9 сая төгрөг тусгай сангийн, 1,496.3 сая төгрөг төрийн сангийн, 613.4 сая төгрөг нь орон нутгийн өмчит байгууллагын үлдэгдэл байна.

Аудитын илрүүлэлт:

Хөвсгөл сумын ОНХС – Тайлант оны эхний үлдэгдлийг 12.1 сая төгрөгөөр дутуу тайлагнасныг аудитын явцад залруулсан.

Замын-Үүд сумын ИТХ -- Арилжааны банкин дахь Засаг даргын Тамгын газрын түр дансаар бэлэн мөнгийг дамжуулан авдаг бөгөөд баримтаар 1.2 сая төгрөг дутагдсанд төлбөрийн акт тогтоосон.

Говь консалтинг менежмент ХХК - Валютаар хийсэн ажил гүйлгээг бүртгэлд тусгахдаа Монгол банкны валютын албан ханшаар тооцоогүйд зөвлөмж өгсөн.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 7,293.5 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 9,372.6 сая төгрөг болж, 2,079.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл, сая төгрөг

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	738.2	211.5	-526.7
Төлбөртэй үйлчилгээний авлага	-	96.5	96.5
Татаас, санхүүжилтийн авлага	-	3.3	3.3
Зээлийн хүүгийн авлага	139.5	102.3	-37.2
Дансны авлага /ТӨҮГ/	1,689.2	2,492.2	803.0
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	2.7	1.2	-1.5
Бусад авлага	872.9	3,553.6	2,680.7
Зээлийн авлага	3,851.0	2,912.0	-939.0
Дүн	7,293.5	9,372.6	2,079.1
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	1,532.0	3,712.7	2,180.7
Төсөл/ сан	4,045.6	3,167.6	-878.0
Төрийн сан	-	-	-
ТӨҮГ болон ОНӨҮГ	1,715.9	2,492.3	776.4
Дүн	7,293.5	9,372.6	2,079.1

Эх сурвалж: Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд 2-оос дээш жилийн насжилттай 710.8 сая төгрөгийн дараах авлага байна. Үүнд:

- Сум хөгжүүлэх сангийн зээлийн үлдэгдэл 530.0 сая төгрөг;
- Сум хөгжүүлэх сангийн зээлийн хүүгийн үлдэгдэл 13.7 сая төгрөг;
- Ажилчидтай холбоотой авлагын үлдэгдэл 12.8 сая төгрөг;
- Бусад авлагын үлдэгдэл 154.3 сая төгрөг байна.

Үүнд 5-аас дээш жилийн насжилттай авлага 100.3 сая төгрөг байна. Хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн, шийдвэрлүүлэх арга хэмжээг авч ажиллаж байна.

Нийт авлагын 2,596.6 сая төгрөг нь сумдын СХС-ийн авлага байна. Мөн зарим сумдын ЭМТ, Өрхийн эмнэлгүүдийн тайлант хугацаанд “Ковид 19” өвчний эмчилгээний зардал болон ЭМДС-аас авах санхүүжилтээр авлага үүсгэж, нийт 1,600.3 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй ажилласан байна.

Мөн аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн тайланд эзэн холбогдогч нь тодорхойгүй, олон жилийн насжилттай 82.0 сая төгрөгийн авлагад 2021 онд албан шаардлага хүргүүлсэн боловч авлага шийдвэрлэгдээгүй байна.

Аудитын илрүүлэлт:

Сайхандулаан сумын ЭМТ - Эрүүл мэндийн даатгалын санхүүжилт дутуу олгогдсоноос үүссэн авлагыг 35.9 сая төгрөгөөр дутуу тайлагнасныг аудитын явцад залруулсан.

Сайншанд сумын СХС - Сумын ерөнхий орлогод шилжүүлсэн санхүүжилтийн дутуу 39.6 сая төгрөгийг авлагаар бүртгээгүй дутуу тайлагнасныг аудитын явцад залруулсан.

Замын-Үүд сумын ЗДТГ - Аймгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй ажлын санхүүжилт 100 сая төгрөгийг СЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлснийг СОК-ын үйл ажиллагаанд зориулалт бусаар зарцуулсан. Мөн тус ажлын санхүүжилтийн 58.0 сая төгрөгийг сумын хөрөнгө оруулалтын сангаас шилжүүлж, 42.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсныг өглөг, авлага тусгаагүй дутуу тайлагнасныг аудитын явцад залруулсан.

Замын-Үүд сумын ОНХС - Авлагын эцсийн үлдэгдлийг 69.7 сая төгрөгөөр дутуу тайлагнасныг аудитын явцад залруулсан.

Өргөн сумын ЕБС – 2020 онд ХХОАТ-ыг 31.7 сая төгрөгөөр урьдчилан төлж авлага үүсгэсэн байна. Тайлант онд тухайн авлагаас 24.0 сая төгрөгийг барагдуулж 7.7 сая төгрөгийн авлагын тооцооны үлдэгдэлтэй шийдвэрлэх зөвлөмж өгсөн.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 1,834.9 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 1,170.5 сая төгрөг болж, 664.4 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь “Чандмань Илч” ОНӨХХК-ийн урьдчилж төлсөн зардал нь 539.8 сая төгрөг болж өмнөх оноос 1,037.5 сая төгрөгөөр буурсан нь нөлөөлжээ.

Хүснэгт №3. Урьдчилгаа дансны үлдэгдэл, сая төгрөг

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	95.0	92.3	-2.7
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	1,580.1	542.1	-1,038.0
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	155.2	535.3	380.1
Цалингийн урьдчилгаа	0.5	0.8	0.3
Томилолтын урьдчилгаа	4.1	-	-4.1
Дүн	1,834.9	1,170.5	-664.4
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	70.0	65.6	-4.4
Төсөл/ сан	184.8	565.1	380.3
Төрийн сан	-	-	-
ТӨҮГ болон ОНӨҮГ	1,580.1	539.8	-1,040.3
Дүн	1,834.9	1,170.5	-664.4

Эх сурвалж: Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэлд 2016 онд үүссэн 6.9 сая төгрөгийн, 2021 онд үүссэн 531.5 сая төгрөгийн урьдчилгаа байна. Он дамжсан 632.1 сая төгрөгийн урьдчилгааны үлдэгдэл байна.

3.5.4 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 9,244.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 11,560.1 сая төгрөг болж, 2,315.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4. Бараа материалын үлдэгдэл, сая төгрөг

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	1,633.7	2,962.3	1,328.6
Дуусаагүй үйлдвэрлэл	-	0.1	0.1
Бэлэн бүтээгдэхүүн	742.5	453.0	-289.5
Хангамжийн материал	6,701.8	7,958.8	1,257.0
Мал амьтад	166.6	185.9	19.3
Дүн	9,244.6	11,560.1	2,315.5
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	7,981.4	9,991.7	2,010.3
Төсөл/ сан	-	-	-
Төрийн сан	-	-	-
ТӨҮГ болон ОНӨҮГ	1,263.2	1,568.4	305.2
Дүн	9,244.6	11,560.1	2,315.5

Эх сурвалж: Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэлд тайлант оны “Чандмань Илч” ОНӨХХК нь Сайншанд суманд дулааны шугам сүлжээний 2 дугаар хэлхээний ажил хийгдэхтэй холбоотойгоор бараа материалын татан авалт хийн, материалын нөөц 1,036.9 сая төгрөг байна.

Аудитын илрүүлэлт:

Алтанширээ, Даланжаргалан, Дэлгэрэх, Улаанбадрах, Хатанбулаг сумдын ЗДТГ-ууд бараа материалын тайланд малыг нас дэвшүүлж бүртгээгүйд зөвлөмж өгсөн.

Алтанширээ, Иххэт, Өргөн сумдын ЗДТГ, Сайхандулаан, Улаанбадрах, Сайншанд 14, Замын-Үүд 7 дугаар Хүүхдийн цэцэрлэгүүд бараа материалын тайланг санхүүгийн тайланд зөрүүтэй дутуу тайлагнасныг аудитын явцад залруулсан.

3.5.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 196,483.9 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 208,730.4 сая төгрөг болж, 12,246.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл, сая төгрөг

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	186,667.9	197,273.9	10,606.0
Биет бус хөрөнгө	9,816.0	11,456.5	1,640.5
Дүн	196,483.9	208,730.4	12,246.5
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	156,689.6	159,791.4	3,101.8
Төсөл/ сан	8,823.7	11,717.7	2,894.0
Төрийн сан	-	-	-
ТӨҮГ болон ОНӨҮГ	30,970.6	37,221.3	6,250.7
Дүн	196,483.9	208,730.4	12,246.5

Эх сурвалж: Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 2,172.9 сая, балансаас баланст шилжүүлэн авсан 10,549.7 сая, үнэ төлбөргүй, хандиваар авсан 23,327.4 сая төгрөгөөр нэмэгдсэн, худалдсан 2,552.0 сая, балансаас баланст шилжүүлсэн 8,721.8 сая, акталсан 4,031.1 сая төгрөгөөр хасагдсан байна.

Дуусаагүй барилга байгууламжийн дансанд 11,717.6 сая төгрөгийн аймаг болон сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн ажил, 1,400.1 сая төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн ажил бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн тайланг буруу тайлагнасан, элэгдлийг зөрүүтэй тооцсон зэрэг 6,935.8 сая төгрөгийн 90 залруулгыг аудитын явцад хийсэн.

Орон нутгийн өмчийг түрээслүүлсний орлогыг дутуу төвлөрүүлсэнтэй холбоотой 5.9 сая төгрөгийн 5 төлбөрийн актыг тогтоосон.

Хөрөнгийн тооллогыг огт хийгээгүй болон үнэн зөв хийгээгүй зэрэг зөрчилд 8 албан шаардлага өгсөн.

Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг шийдвэрлээгүй зөрчилд 56 зөвлөмж өгсөн байна.

3.5.6 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалт дансны эхний үлдэгдэл 40.6 сая, эцсийн үлдэгдэл 4,452.3 сая төгрөг болж, 4,411.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6. Урт хугацаат хөрөнгө оруулалт, сая төгрөг

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт /+/, бууралт /-/
Урт хугацаат хөрөнгө оруулалт	40.6	4,452.3	4,411.7
ДҮН	40.6	4,452.3	4,411.7
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Төрийн сан	40.6	4,452.3	4,411.7
ТӨҮГ болон ОНӨҮГ	-	-	-
ДҮН	40.6	4,452.3	4,411.7

Эх сурвалж: Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урт хугацаат хөрөнгө оруулалт дансны үлдэгдэлд бүртгэлтэй 17.4 сая төгрөг нь 1997 онд дампуурсан Сэргээн босголт банкны үлдэгдэл, 23.2 сая төгрөг нь Сангийн яамнаас зээлээр авсан өвсний мөнгийг буцаан аймгийн орон нутгийн орлогоос суутгуулж зээлийг хаасан хөрөнгө, 4,411.7 сая төгрөг нь Азийн хөгжлийн банкны эргэн төлөгдөх нөхцөлтэй цэвэрлэх байгууламжийн хөрөнгө оруулалт байна.

3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 20,490.7 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 23,112.4 сая төгрөг болж, 2,621.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №7. Нийт өр төлбөрийн үлдэгдэл, сая төгрөг

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт /+/, бууралт /-/
Богино хугацаат өр төлбөр	3,808.0	5,230.2	1,422.2
Ажилчидтай холбогдсон өглөг	32.1	304.3	272.2
Бараа үйлчилгээний зардлын өглөг	343.2	406.2	63.0
Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг	-	-	-
Байгууллагад төлөх өглөг	2,176.9	3,160.8	983.9
Хувь хүмүүст төлөх өглөг	14.3	28.1	13.8
Татварын өглөг/ТӨҮГ/	148.3	480.0	331.7
НДШ-ийн өглөг/ТӨҮГ/	1.3	-	-1.3
Дансны өглөг /ТӨҮГ/	413.1	832.0	418.9
Урьдчилж орсон орлого	678.8	18.8	-660.0
Урт хугацаат өр төлбөр	16,682.7	17,882.2	1,199.5

Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	5,236.8	6,330.2	1,093.4
Бусад урт хугацаа өр төлбөр /ТӨҮГ/ Төслийн зээл	11,445.9	11,552.0	106.1
	-	-	-
ДҮН	20,490.7	23,112.4	2,621.7
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	1,469.0	2,492.2	1,023.2
Төсөл, сан	503.8	356.3	-147.5
Төрийн сан	5,246.5	6,331.8	1,085.3
ТӨҮГ болон ОНӨҮГ	13,271.4	13,932.1	660.7
ДҮН	20,490.7	23,112.4	2,621.7

Эх сурвалж: Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд ажилчидтай холбоотой өглөг, бараа үйлчилгээний зардлын өглөг 710.5 сая төгрөг, байгууллага болон хувь хүмүүст төлөх өглөг 3,188.9 сая төгрөг, татвар болон дансны өглөг 1,312.0 сая төгрөг, урьдчилж орсон орлого 18.8 сая төгрөг байна.

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд Чандмань-Илч ОНӨХХК-д шилжүүлсэн орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөвт ажлын 11,540.4 сая төгрөг, гадаад валютаарх Азийн хөгжлийн банкны төслийн зээл 1,918.5 сая төгрөг, Дагшин-Эрдэнэ ОНӨХХК-ийн 11.7 сая төгрөгийн урт хугацаат зээл бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

Мандах сумын ОНХС - Тайлант онд дууссан 1 ажлын үлдэгдэл санхүүжилт 27.0 сая төгрөгийг өглөг үүсгээгүй зардалд бүртгэн тайлагнасныг аудитын явцад залруулсан.

Замын-Үүд сумын ЗДТГ - Аймгийн хөрөнгө оруулалтын ажлын төсвийг сумын Онцгой комиссын үндсэн үйл ажиллагаанд зарцуулж 100.0 сая төгрөгийн өглөг үүсгэсэн зөрчилд албан шаардлага өгсөн.

3.5.8 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 203,921.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 221,320.0 сая төгрөг болж, 17,398.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №8. Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл, сая төгрөг

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт /+/, бууралт /-/
Засгийн газрын оруулсан капитал			
/Засгийн газрын сан/ орон нутгийн сан	53,850.3	56,106.1	2,255.8
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	23,889.4	23,029.1	-860.3
Өмч /хувийн/ /ТӨҮГ/	0.1	1.0	0.9
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	676.2	514.4	-161.8
Хуримтлагдсан үр дүн	77,736.5	99,147.1	21,410.6
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	47,768.7	42,522.3	-5,246.4
ДҮН	203,921.2	221,320.0	17,398.8
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	166,372.1	172,281.2	5,909.1
Төсөл, сан	11,924.5	21,562.0	9,637.5
Төрийн сан	4,069.1	888.6	-3,180.5
ТӨҮГ болон ОНӨҮГ	21,555.5	26,588.2	5,032.7
ДҮН	203,921.2	221,320.0	17,398.8

Эх сурвалж: Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оруулсан капитал дансны эцсийн үлдэгдэл 56,106.1 сая төгрөг болж, 2,255.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Сайншанд сумын Хүүхдийн 14 дүгээр цэцэрлэг, Замын-Үүд сумын Хүүхдийн 1, 7 дугаар цэцэрлэг байгууллагын эзэмшдэг нийт 67.0 сая төгрөгийн газрыг үнэлж засгийн газрын капитал дансанд бүртгэсэн, Нийтлэг үйлчилгээний газрын үйл ажиллагааны чиглэл нь орон нутгийн өмчит аж ахуйн нэгжээс төсөвт байгууллага болсонтой холбоотой 1,698.9 сая төгрөгөөр нэмэгдсэн, Дорноговь аймгийн Ахмадын сан, Сайншанд Агатова ӨЭМТ ковидтой холбоотой үнэ төлбөргүй 489.9 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.

Орон нутгийн өмчит байгууллагын төрийн өмч, эздийн өмч данс буурсан нь Чандманьбадрал ОНӨХХК орон нутгийн өмчөөс төрийн өмчид шилжсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

"Замын-Үүд НААҮ" ОНӨХХК Санхүүгийн тайлан дахь орон нутгийн өмчийн дүн нь улсын бүртгэлийн гэрчилгээний дүнгээс 4,100.0 сая төгрөгөөр зөрүүтэй байсан зөрчилд зөвлөмж өгсөн.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Хүснэгт №9. Төсвийн орлого /сая төгрөг/

№	Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Цалин хөлс түүнтэй адилтгах бусад орлого	15,500.0	17,174.0	1,674.0	110.8
2	Хувь хүний орлогын албан татварын буцаалт	-803.8	-803.8	-	100.0
3	Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	1,157.0	1,310.7	153.7	113.3
4	АТБӨЯХ-ийн албан татвар	730.0	816.9	86.9	111.9
5	Газрын төлбөр	2,105.9	1,516.4	-589.5	72.0
6	Рашаан ус ашигласны төлбөр	378.8	546.6	167.8	144.3
7	Бусад төлбөр хураамж	1,100.0	157.0	-943.0	14.3
8	Түрээсийн орлого	47.0	48.4	1.4	102.9
9	Хүү торгуулийн орлого	550.0	755.4	205.4	137.3
10	Нэр зааж ангилагдаагүй орлого	705.0	506.7	-198.3	71.9
11	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	30.0	30.5	0.5	101.6
12	Дуудлага худалдааны орлого	9,154.2	3,147.7	-6,006.5	34.4
	НИЙТ	30,654.1	25,206.5	5,447.6	82.2

Эх сурвалж: Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 63,789.6 сая төгрөгөөр, нийт зарлагыг 63,789.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 37,949.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 101,738.9 сая төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээг санхүүжүүлэхээр 101,738.9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр нийт 91,653.7 сая төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэр бүрдэж, нийт зардлын гүйцэтгэл 87,805.0 сая төгрөг байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 87,805.0 сая төгрөг буюу 86.3 хувьтай байгаа нь цалин хөлс 602.5 сая, ажил олгогчоос олгох нийгмийн даатгалын шимтгэл 267.5 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 478.4 сая, нормативт зардал 198.2 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 1,248.3 сая бараа үйлчилгээний бусад 880.4 сая, урсгал шилжүүлэг 2,100.0 сая төгрөг, хөрөнгийн зардал 7,946.3 сая төгрөгийг зарцуулаагүйтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжаас 137.8 сая, ЗДНХ, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс 110.0 сая, дээд шатны төсвийн захирагчийн төсвөөс 1,945.4 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 4,504.7 сая, ЭМД-ын сангийн нэмэлт орлогоос 643.2 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс: цалин хөлс, АОТНДШ-д 141.8 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 48.4 сая, хангамж бараа материалын зардалд 199.7 сая, нормативт зардалд 615.7 сая, эд хогшил урсгал засварын зардалд 323.0 сая, томилолтын зардалд 15.2 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжид 3,371.1 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 903.4 сая урсгал шилжүүлэгт 329.3 сая, хөрөнгийн зардалд 522.9 сая төгрөгийг зарцуулсан зарцуулж, үлдэгдэл 810.8 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.7.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 154 мэдээллээс хугацаандаа оруулсан 152 мэдээлэл оруулсан, хугацаа хоцроосон 2 мэдээлэл байна.

Аудитын илрүүлэлт:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаагүй 55 төсвийн шууд захирагчид 5 зөвлөмж, 50 албан шаардлага, 9 төсвийн төвлөрүүлэн захирагчид 1 зөвлөмж, 8 албан шаардлага, 4 ОНӨААН-д 1 зөвлөмж, 3 албан шаардлага өгсөн.

3.7.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.8 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 1 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 9 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	-	-	-	-	-	-	-
Албан шаардлага	1	122.6	-	-	1	122.6	-
Зөвлөмж	1	-	1	-	-	-	100
Нийт	2	122.6	1	-	1	122.6	50

3.9 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тусгай шилжүүлгийн санхүүжилтээр санхүүждэг сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн төвийн тогтмол зардлын санхүүжилтийн төлөвлөгөө 6,161.9 сая төгрөг, гүйцэтгэлээр 5,759.4 сая төгрөгийг олгож, 402.5 сая төгрөгийг зөрүүтэй буюу бодитой төлөвлөөгүй байна.

/Хөвсгөл сумыг төвлөрсөн шугамд 2021 онд холбож ашиглалтад оруулаагүйгээс, ЕБС, Хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагаа ковидын улмаас зогссон үед цахилгаанаар халдаг сургууль, цэцэрлэгийн халаах талбайн хязгаарлалт хийсэн зэрэг зардлыг хэмнэлтийн горимд шилжүүлж ажилласан гэсэн тайлбарыг ирүүлсэн/

4. Аудитын илрүүлэлт

Дорноговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 133 төсвийн байгууллага, 7 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 29 тусгай сан, 14 төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайлан, нийт 183 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 183 байгууллага аудитад хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас 84 байгууллагыг түүвэрт хамруулж, 99 байгууллагад дүгнэлт хүргүүлээ. Үүнд: “Зөрчилгүй” 85, “Хязгаарлалттай” 12, “Татгалзсан” 2 дүгнэлт /Замын-Үүд сумын Засаг даргын Тамгын газар, Замын-Үүд сумын НААҮ ОНӨХХК/ авсан байна.

Аудитаар нийт 39,000.9 сая төгрөгийн 711 алдаа, зөрчил илрүүлснээс 37,659.2 сая төгрөгийн 293 алдааг залруулж, 117.3 сая төгрөгийн зөрчилд 38 төлбөрийн акт тогтоож, 856.3 сая төгрөгийн зөрчилд 183 албан шаардлага, 368.1 сая төгрөгийн зөрчилд 197 зөвлөмж өглөө.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар

Аудитаар илэрсэн зөрчилд нийт 721.4 сая төгрөгийн 34 алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 707.0 сая төгрөгийн 11 алдааг залруулж, 10 албан шаардлага өгч, 14.4 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 13 зөвлөмж өглөө. 13 төсвийн төвлөрүүлэн захирагчид зөрчилгүй, 1 төсвийн төвлөрүүлэн захирагчид хязгаарлалттай /Замын-Үүд сум/ дүгнэлт өгсөн.

Төсвийн шүүд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа төсвийн 133 байгууллагаас 55 санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, зөрчилгүй 66, хязгаарлалттай 11, татгалзсан 1 /Замын-Үүд сумын ЗДТГ/ дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 8,372.9 сая төгрөгийн 554 алдаа, зөрчил илрүүлснээс 7,308.8 сая төгрөгийн 201 алдааг залруулж, 39.3 сая төгрөгийн зөрчилд 33 төлбөрийн акт тогтоож, 811.8 сая төгрөгийн зөрчилд 62 албан шаардлага, 213.0 сая төгрөгийн алдаа, зөрчилд 158 зөвлөмж өгсөн.

Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа орон нутгийн өмчит 7 аж ахуйн нэгж байгууллагаас 6 байгууллагад зөрчилгүй, 1 байгууллагад татгалзсан /Замын-Үүд НААҮ ОНӨХХК/ дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 878.9 сая төгрөгийн 47 алдаа, зөрчил илрүүлснээс 753.0 сая төгрөгийн 20 алдааг залруулж, 2.8 сая төгрөгийн зөрчилд 8 албан шаардлага, 123.1 сая төгрөгийн алдаа, зөрчилд 19 зөвлөмж өгсөн.

Тусгай санд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа 29 санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан.

Аудитаар нийт 29,027.8 сая төгрөгийн 72 алдаа, зөрчил илрүүлснээс 28,890.4 сая төгрөгийн 61 алдааг залруулж, 78.0 сая төгрөгийн зөрчилд 5 төлбөрийн акт, 41.8 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 17.6 сая төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгсөн.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар

Аудитаар илэрсэн зөрчилд 4 алдаа, зөрчил илрүүлж, 1 албан шаардлага өгч, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

4.1 Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн албан шаардлага

Шилэн дансны цахим системд 8,896.1 сая төгрөгийн 21 захирамжийг мэдээлээгүй, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтыг мэдээлэх хэсэгт таван сая хүрэхгүй үнийн дүнтэй болон шаардлагагүй гүйлгээнүүдийг мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2-д “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.4.4-д “таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, 6.4.8-д “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

4.2 Төсвийн ерөнхийлөн захирагчид өгсөн зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Ажил гүйлгээний ангитай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Тайлант онд төсвийн орлого 30,654.1 сая төгрөгийн төлөвлөгөөнөөс 25,206.5 сая төгрөгийн гүйцэтгэлтэй буюу 82.2 хувьтай биелсэн байна. Орлогыг үндэслэлгүй төлөвлөснөөс нийт 5,447.6 сая төгрөгөөр орлого тасарсан байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Төсвийн орлогыг бодит тоон мэдээлэлд үндэслэн төлөвлөх, батлагдсан орлогын төлөвлөгөөг биелүүлэх талаар арга хэмжээ авч ажиллах.

2. Тодруулгатай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Сумдын Сум хөгжүүлэх сан 104.0-826.8 сая хүртэлх, сумдын ЭМТ 103.6-753.5 сая хүртэлх, Эм эргэлтийн сан 255.4 сая, Чандмань-Илч ХХК 2,234.6 сая төгрөгийн материаллаг хэмжээний авлагууд байна. Замын-Үүд ЗДТГ 118.3 сая, Агатова ЭМТ 171.6 сая, Сайншанд ОНХС 215.7 сая, Эм эргэлтийн сан 507.3 сая, Засаг дарга 1,045.5 сая, Чандмань-Илч ХХК 15,274.4 сая төгрөгийн материаллаг хэмжээний өглөгийг тайлагнасан буюу өмнөх оноос өссөн байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өр, авлага үүсгэхгүй ажиллах, нэгтгэлд хамрагдаж буй байгууллагуудын үүссэн авлага, өр төлбөрийг барагдуулах талаар төсвийн шууд захирагч нарт даалгаж, үр дүнтэй арга хэмжээ авч ажиллах, биелэлтийг хянах.

3. Дансны үлдэгдэлтэй холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:

Дорноговь салбарын Монгол шуудан банкинд 2007 онд “Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих” зээлийн чиглэлээр орон нутгийн төсвөөс ААНБ-аас төсөл сонгон шалгаруулах зориулалтаар олгосон санхүүжилтийн үлдэгдэл 30 сая төгрөг одоогийн Төрийн банкны 281500346241 дансанд байсаар байна.

3.2 Өгсөн зөвлөмж:

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “ерөнхий нягтлан бодогч нь дараах үүрэг хүлээнэ... эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Арилжааны банкны дансанд байгаа хөрөнгийн асуудлыг шийдвэрлэж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 11 дүгээр сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.